



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ТОГТООЛ

2014 оны 01 сарын 03 өдөр

Дугаар 01

Жаргалант

「 Мал эмнэлэг үржлийн ажил үйлчилгээний
үнэлгээг тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, Малын удмын сан эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4.1 дэхь заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Мал эмнэлэг үржлийн ажил үйлчилгээний төлбөрийн хэмжээг хавсралтаар баталсугай.

Хоёр. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга Д.Сайнбилэг, Мал эмнэлэг үржлийн тасагт даалгасугай.


Гурав. Энэ тогтоол гарсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2009 оны 29 дүгээр тогтоолыг хүчингүй болгосугай.

ДАРГА  Д. ГАНТӨМӨР



1513099

togtool-2014



МАЛ ЭМНЭЛЭГ ҮРЖЛИЙН АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ

Ажил үйлчилгээний төрөл	Малын төрөл	Хэмжих нэгж	Хуучин үнэ /төг/	Шинэ үнэ /төг/	Хэдэн удаа үйлчилгээ явуулах	
Мал амьтны эрүүл мэндийн үзлэг	Бод	толгой	100	200	Малыг хөлөөр тууварлах	
	Бог	толгой	50	100		
Сүргийн ерөнхий үзлэг	Бод	толгой	500	5000	Малыг хөлөөр тууварлах	
	Бог	толгой	300	3000		
Туулга	Бод	толгой	250	250	1 удаа	
	Бог	толгой	150	200	1 удаа	
	Нохой, муур	толгой	400	400	Улиралд	
Угаалга	Бод	толгой	500	500	1 удаа	
	Бог	толгой	200	200	1 удаа	
Боловсруулалт /ивомек/	Бод	толгой	200	250	1 удаа	
	Бог	толгой	150	200	1 удаа	
Шинжилгээ	Гулууз мах		ширхэг	200		
	Жижиглэн мах	Бод	кг	25		
		Бог	кг		25	
	Сүү цагаан идээ		кг		30	
	Өвчтэй ба үхсэн малын		дээж		3000	
Мал амьтны гаралтай түүхий эд бүтээгдэхүүн	Бүх төрлийн арьс, шир		ширхэг	25-300	25	
	Ноос, хөөвөр, хялгас		кг	50	30	
	Ноолуур		кг		60	
Ариутгал, халдваргүйжүүлэлт	Хашаа саравч, байр		м ²	130	200	
	Арьс шир		ширхэг	200	200	
Мэс ажилбар	Бод	толгой	3000	20.000		
	Бог	толгой	2000	5.0-10.000		
Керсавер	Бод	толгой		100.000		
	Бог	толгой		20.000		



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2014 оны 01 сарын 03 өдөр

Дугаар 02

Жаргалант

┌ Соёлын төвийн ажил үйлчилгээний ┐
үнэ тариф тогтоох тухай

Сумын соёлын төвийн ажил үйлчилгээний үнэ тариф тогтоолгох тухай соёлын төвийн эрхлэгч Н.Өнөртүвшингийн мэдээллийг хэлэлцээд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, 20 дугаар зүйлийн 20.1.14 дэхь заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь:


Нэг. Сумын соёлын төвийн ажил үйлчилгээний үнэ тарифын хэмжээг хавсралтаар баталсугай.

Хоёр. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж, мөрдөж ажиллахыг сумын Засаг дарга Д.Сайнбилэг, соёлын төвийн эрхлэгч Н.Өнөртүвшин нарт даалгасугай.

ДАРГА  Д.ГАНТӨМӨР



1513101



СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН АЖИЛ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭ ТАРИФ

№	Үйлчилгээний төрөл	Төрөл	Төгрөг
1	Урлагийн тоглолт, жүжиг, кино	Том хүн	1500-2000
		Хүүхэд	1000-2000
2	Хөтөлбөрт үдэшлэг	Том хүн	1500-2000
		Хүүхэд	500-1000
3	Албан байгууллага, аж ахуйн нэгжүүд нэг удаагийн үйл ажиллагаа явуулахад		10000
4	Албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэд томоохон тэмдэглэлт болон ойн баярын арга хэмжээ зохион байгуулахад		50000



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014 оны 01 сарын 03 өдөр

Дугаар 03

Жаргалант

「Аймгийн сайн малчинд тодорхойлох тухай」

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.14, Баянхонгор аймгийн Засаг даргын 2009 оны 436 дугаар захирамжийг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Тус сумын 2 дугаар багийн малчин Б.Алтанхуяг, Б.Жүгдэр, 1 дүгээр малчин Ё.Нямдаваа нарыг аймгийн “Сайн малчин”-аар шагнуулахаар тодорхойлсугай.

Хоёр. Б.Алтанхуяг, Б.Жүгдэр, Ё.Нямдаваа нарыг аймгийн “Сайн малчин”-аар шалгаруулж өгөхийг аймгийн Засаг дарга даргаас хүссүгэй.



ДАРГА *[Signature]* Д.ГАНТӨМӨР

1512029

togtool-2014



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2014 оны 01 сарын 13 өдөр

Дугаар 04

Жаргалант

Г Хуралдааны тов зарлах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3 дахь заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанас ТОГТООХ нь:

Нэг. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааныг 2014 оны 01 дүгээр сарын 15 -ны өдрийн 10 цагт хуралдуулсугай.

Хоёр. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар дараах асуудлуудыг хэлэлцүүлсүгэй.

1. Сумын 2014 оны төсөв баталсан тогтоолд өөрчлөлт оруулах тухай.
2. Б.Санжаасүрэнг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчөөс чөлөөлөх тухай

Гурав. Хуралдаанаар хэлэлцэхээр шийдвэрлэсэн асуудлуудыг сайтар бэлтгэн материалыг нэгээс доошгүй хоногийн өмнө төлөөлөгчдөд тараах ажлыг зохион байгуулахыг ИТХ-ын ажлын алба, сумын Засаг дарга /Д.Сайнбилэг/-д даалгасугай.

ДАРГА  Д.ГАНТӨМӨР



1513103



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2014 оны 01 сарын 13 өдөр

Дугаар 05

Жаргалант


Иргэний танхимын зөвлөлийн бүрэлдэхүүн, ¹
ажиллах журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 20.1.4, 20.1.6 дахь заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн хуралдаанас ТОГТООХ нь:

Нэг. Сумын ИТХ-ын дэргэдэх "Иргэний танхим"-ын зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах журмыг хоёрдугаар хавсралт ёсоор баталсугай.

Хоёр. "Иргэний танхим"-ын үйл ажиллагааг журмын дагуу иргэдэд хүртээмжтэй, үр дүнтэй зохион байгуулж, ажлын тайланг сар бүрийн 30-нд сумын ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулж ажиллахыг "Иргэний танхим"-ын Зөвлөлийн даргад, иргэдээс ирсэн санал, хүсэлт, гомдлыг долоо хоног бүрийн Баасан гарагт сумын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт танилцуулж ажиллахыг сумын Иргэний танхимын ажилтан /М.Нарантогтох/-д үүрэг болгосугай.

ДАРГА  Д.ГАНТӨМӨР



1513105

togtool-2014

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны
05 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



БАЯНХОНГОР АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДЭРГЭДЭХ
ИРГЭНИЙ ТАНХИМЫН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- | | |
|-------------------|---|
| 1. Д.Уранчимэг | /ИТХ-ын нарийн бичгийн дарга / |
| 2. Д. Ганзориг | /Тамгын газрын дарга / |
| 3. Ө.Бямба | /Нийгмийн хөгжлийн ажилтан / |
| 4. Д.Пагмасүрэн | /Сумын ҮЭ-ийн тэргүүн / |
| 5. Н.Соронзонболд | /Сумын ИХ-н төлөөлөгч, 4-р багийн ИНХ-ын дарга/ |
| 6. Т.Пүрэвжав | /Сумын Эмэгтэйчүүдийн холбооны тэргүүн / |
| 7. Б.Бааваа | /Сумын Ахмадын холбооны дарга / |
| 8. Г.Энхцэцэг | /Сумын залуучуудын холбооны дарга / |
| 9. Ш.Оюунцэцэг | /Сумын төрийн сангийн төлөөлөгч / |
| 10. З.Галбадрах | /Сумын ХБИ-ийн холбооны дарга / |
| 11. Д.Баярмагнай | /Байдрагийн хөгжил ТББ-ын тэргүүн / |



БАЯНХОНГОР АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН ДЭРГЭДЭХ
ИРГЭНИЙ ТАНХИМЫН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл :

Төрийн хууль тогтоомж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал /цаашид “Хурал” гэх / сумын Засаг дарга болон нутгийн захиргааны байгууллагаас гаргаж буй бодлого шийдвэрт иргэдийн байр суурь, үзэл бодлыг тусгах, иргэдийн санлыг шийдвэр гаргагчид сонсгох, олон нийтийн тусгах санаачилсан болон орон нутгийн түвшинд тулгамдсан асуудлыг ил тод, нээлттэй хэлэлцэх зорилгоор ажиллах сумын ИТХ-ын дэргэдэх иргэний танхимын /цаашид “танхим” гэх /үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.

Хоёр. Зорилго үйл ажиллагааны зарчим:

2.1 Иргэний танхимын зорилго нь хууль тогтоомж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчид, Засаг даргын шийдвэрийн төсөл, шийдвэрт оруулах нэмэлт өөрчлөлт, орон нутгийн тулгамдсан асуудлыг олон нийтээр хэлэлцүүлэн иргэдийн санал бодлыг бодитойгоор тусган хууль ёсны эрх ашигт нь нийцсэн шийдвэр гаргахад оршино.

2.2 Хууль тогтоомжийг иргэдэд сурталчилах, тайлбарлан таниулах, хуулийн зөвөлгөө өгөх, сургалт зохион байгуулж иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэнэ.

2.3 Танхимын үйл ажиллагаа олон нийтэд ил тод, нээлттэй байна.

2.4 Танхимд болох аливаа хэлэлцүүлэг нь тодорхой шийдвэр, баримт бичгийн төслийг үндэслэн, сумын Хурал, түүний Тэргүүлэгчид, сумын Засаг даргаас шийдвэр гаргахын өмнөх шатанд явагдана. Төсөлд өөрчлөлт оруулах, төслийг шийдвэр болгон гаргахдаа Иргэний танхимд болсон нээлттэй хэлэлцүүлэгт үндэслэнэ.

2.5 Танхимын үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог идэвхжүүлэн нэмэгдүүлэх зорилгоор орон нутаг дахь Төрийн бус болон хэвлэл мэдээллийн байгууллагатай байнгын үр дүнтэй хамтын ажиллагааг хөгжүүлж, мэдээллийн бүх суваг, хэрэгслийг ашиглана.

Гурав. Иргэний танхимын үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт:

3.1 Танхимын үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь нээлттэй хэлэлцүүлэг байна. Нээлттэй хэлэлцүүлэгийг сар бүр тогтмол хийх ба зайлшгүй шаардлагатай тохиолдолд сард нэг хүртэл удаа нэмэлт хэлэлцүүлэг зохион байгуулж болно. Нээлттэй хэлэлцүүлэг нь оролцогч тал, асуудал оруулагч тал болон зохион байгуулагчаас тус тус бүрдэнэ.

3.2 Нээлттэй хэлэлцүүлэгт оролцогч нь Монгол Улсын иргэн, аж ахуй нэгж байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл байна.

3.3 Нээлттэй хэлэлцүүлэгт асуудал оруулагч нь сумын ИТХ-ын дарга, Төлөөлөгч, хурлын Тэргүүлэгчид, нарийн бичгийн дарга, сумын Засаг дарга, түүний Тамгийн газар, хэсэг, тасаг мэргэжилтнүүд болон Засаг даргын зөвлөлийн гишүүд, Иргэний танхимын зөвлөл, төрийн бус байгууллагууд, сумын Хурлын болон Засаг даргын шийдвэрээр байгуулагдсан ажлын хэсэг, иргэн байна.

3.4 Асуудал оруулж буй албан тушаалтан, ажлын хэсэг, Иргэний танхимын зөвлөл, хэсэг, тасгийн төлөөлөл нь тухайн асуудлаар явагдаж буй нээлттэй хэлэлцүүлгийн үр дүнг нэгтгэн дүгнэж, холбогдох албан тушаалтанд танилцуулана.

3.5 Танхимын үйл ажиллагааг зохион байгуулагч нь сумын Иргэний танхимын зөвлөл /цаашид “зөвлөл” гэх / байна.

- Зөвлөлийн бүрэлдэхүүнийг сумын ИТХ-ын Тэргүүлэгчидийн хурлаар хэлэлцэн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор баталгаажуулна.
- Зөвлөлийн бүрэлдэхүүнд сумын ИТХ, Засаг даргын зөвлөл, нутгийн захиргааны болон төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн төлөөлөл байна.
- Зөвлөлийн хуралд оролцогчдын олонхийн санал шийдвэр хүчин төгөлдөр байх бөгөөд зөвлөлийн хурлын дэг “Танхимын зөвлөлийн ажиллах журам”- ийг зөвлөлийн бүрэлдэхүүн өөрөө тогтоож мөрдөнө.
- Зөвлөлийн бичиг баримтын хэвлэмэл эх нь сумын ИТХ-ын албан хэрэг хөтлөлтийн бичиг баримтын хамт байх ба шийдвэр нь тогтоол хэлбэрээр гарна.

3.6 Зөвлөлийн анхдугаар хуралд оролцогчдын олонхийн саналаар дарга, нарийн бичгийн даргыг сонгоно.

3.7 Зөвлөл, Танхимын өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан ажиллах ажилтны ажлын байрны тодорхойлолтыг ИТХ-ын Нарийн бичгийн дарга боловсруулж, үр дүнгийн гэрээ байгуулж ажиллана.

5.1.3 Танхимд болох хэлэлцүүлэгт биечлэн оролцож, санал хүсэлтээ илэрхийлэхээ бүртгүүлэх хэлбэрээр

5.2 Танхимын нээлттэй хэлэлцүүлэгт өөрийн санал, байр суурийг илэрхийлэхэд хангалтгүй мэдээлэлтэй байна гэж үзвэл иргэд хэлэлцүүлэг болохоос 3-аас доошгүй өдрийн өмнө төсөл боловсруулагч буюу асуудал оруулагч талд асуулт тавьж, хариулт авч болно. Хариултыг төсөл боловсруулагчид Иргэний танхимын хэлэлцүүлэгийн үеэр өгнө.

5.3 Төсөл боловсруулагчид хэлэлцүүлэг болохоос өмнө бичгээр ирсэн саналыг нэгтгэж, ирсэн санал бүрийг тайлбарын хамт төсөлд хавсарган Танхимын хэлэлцүүлэгт бэлтгэнэ.

5.4 Хэлэлцүүлэг эхлэхээс өмнө төсөлд өөрчлөлт орсон бол төсөл боловсруулагчид үг өөрчлөлтийн талаар хэлэлцүүлэгийн эхэнд мэдээлж, тайлбар хийнэ.

Зургаа. Нээлттэй хэлэлцүүлэгт оролцогчдод урьдчилсан болзол тавихгүй байх зарчим:

6.1 Нээлттэй хэлэлцүүлэгт оролцогчдод урьдчилсан болзол тавихгүй байх зарчим үйлчилнэ.

6.2 Хэлэлцүүлэгт оролцогч иргэн нь өөрийн байр суурь, үзэл бодлыг илэрхийлэхээс гадна ажиглагчийн байр сууринаас оролцох эрх нь нээлттэй байна. Түүнчлэн хэлэлцүүлэг зохион байгуулагчийн урилгаар төрийн албан хаагчид шинжээч, мэргэжилтэн, судлаач, эрдэмтэн нар оролцож болно.

6.3 Хэлэлцүүлэгт оролцох иргэний тоо Танхимын суудлаас илүү олноор оролцох тохиолдолд хэлэлцүүлгийг хэсэгчлэн болон өөр байр танхимд хийж болно.

6.4 Ижил байр суурьтай иргэд олноор бүртгэгдсэн тохиолдолд иргэд дундаасаа төлөөлөл сонгож хэлэлцүүлэгт оролцуулах болно.

Долоо. Хэлэлцүүлгийн бэлтгэл хангах.

7.1 Танхимын ажилтан нь хэлэлцүүлэгт биечилэн оролцохыг хүсэгчдийн үг хэлэх дарааллыг тогтоох зорилгоор хэлэлцүүлэг болохоос ажлын 2-5 хоногийн өмнөх өдөр утас, электрон, шуудангийн хаягаар ирүүлсэн иргэдийн нэрсийг бүртгүүлсэн өдөр, цагийн дарааллаар жагсааж, хэлэлцүүлэг зохион байгуулагчид танилцуулсан байна.

7.2 Танхимын ажилтан нь хэлэлцүүлгийн танхимыг бэлтгэх, хэлэлцүүлгийн үеийн тэмдэглэл хөтлөх, хэлэлцүүлэг даргалагчийн хүсэлтээр хэлэлцүүлгийн дэг алдуулагчийг танхимаас гаргах, хэлэлцүүлгийг хэвлэл мэдээлэлээр дамжуулах, хэвлэл мэдээллийн ажилтнуудыг урьж оролцуулах ажлыг хариуцан гүйцэтгэнэ.

7.3 Танхимын ажилтан хэлэлцүүлгийн үеэр аудио болон видео материал үзүүлж сонсох, зураг үзүүлэн таниулах материал байрлуулах, компьютерээр материал үзүүлж таниулах, оролцогчдын материал зэргийг асуудал оруулагч талын хамт бэлтгэж, хэлэлцүүлэг эхлэхээс 1-2 цагийн өмнө зохион байгуулалтын болон техникийн бэлтгэлийг бүрэн хангасан байна.

7.4 Танхимын ажилтан нээлттэй хэлэлцүүлгийг хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр шууд дамжуулах, хэлэлцүүлэгт сэтгүүлч, сурвалжлагч, ажиглагч нарыг нэвтрүүлэх тэдэнд суудал, байрлал хувиарлах зэрэг бэлтгэл ажлыг нээлттэй хэлэлцүүлэг эхлэхээс өмнө хийж гүцэтгэнэ.

Хэлэлцүүлэгт оролцохоор ирсэн хүмүүсийг угтан авч, хэлэлцүүлгийн үеэр үг хэлэх дарааллыг тогтооход хэрэглэгдэх жагсаалт, бүртгэл, оролцох хүмүүсийн нэрийн жагсаалтыг хэлэлцүүлэг даргалагчийн гаргасан маягтын дагуу хийж гүйцэтгэн, хэлэлцүүлэг даргалагчид бэлтгэн өгсөн байна.

Найм. Хэлэлцүүлгийн дэг:

8.1 Хэлэлцүүлэгт оруулж буй төслийн нэр, хэлэлцүүлэг зарласан огноо, хэлэлцүүлгийн танхимын оролцогчдын тоо, хэлэлцүүлэгт асуудал оруулж буй төсөл боловсруулагчид, хэлэлцүүлгийг даргалах хүний нэр, албан тушаал, хэлэлцүүлэгт оролцож буй бусад албаны хүмүүсийг хэлэлцүүлэг зохион байгуулагч буюу зөвлөлийн бүрэлдэхүүнээс томилогдсон албан тушаалтанг танилцуулж хэлэлцүүлгийг нээнэ.

8.2 Иргэний танхимд болох хэлэлцүүлгийг Иргэний танхимын зөвлөлийн гишүүд ээлж дараалан зохион байгуулж, даргалан явуулна.

Даргалагч хэлэлцүүлгийн дэгийг оролцогчдод танилцуулан, хэлэлцүүлэгт оролцогчдын тоо хэлэлцэх асуудлын нарийн төвөгтэй байдлыг харгалзан хэлэлцүүлэгийн хийт хугцаа, нэг оролцогчийн үг хэлэх хугцааг тус тус тогтооно. Ингэхдээ нэг хүний үг хэлэх хугацааг 3-5 минутаар тогтоож болно.

8.3 Хөгжлийн болон хэл ярианы бэрхшээлтэй хүмүүст үг хэлэх хугацааг шаардлагатай хэмжээгээр сунгаж болох ба ингэхдээ нэг хүн А-4 хэмжээний бүтэн хуудас материал уншиж танилцуулаж чадахуйц хэмжээгээр цаг олгоно.

8.4 Төсөл боловсруулагч ажлын хэсгийн гишүүн хэлэлцүүлэгт оролцогчдод төслийг танилцуулна.

8.5 Оролцогчдын үг хэлэх дарааллыг хэлэлцүүлэг даргалагч тогтооно. Ингэхдээ энэ журмын 7.4 дэхь заалтын дагуу бүртгүүлсэн нэрсийн дарааллыг үндэслэн дараах дэс дарааллыг баримтлан индэрт урина. Үүнд :

8.5.1 Хөндлөнгийн шинжээч, мэргэжилтэн экспорт, төрийн болон олон улсын байгууллагын холбогдох албаны хүмүүс үг хэлэх, төслийг бүхэлд нь буюу тодорхой хэсгийг дэмжсэн болон эсэргүүцсэн байр суурьтай хүмүүс болон гарч үг хэлэх, тайлбар, саналтай хүмүүс үг хэлнэ.

8.5.2 Хэрэв төслийг дэмжсэн, эсэргүүцсэн, төсөлд санал тайлбар хийхийг хүссэн хүний тоо тус бүр 3-аас илүү бүртгэгдсэн бол тэдгээр байр суурьтай хүмүүс ээлжлэн үг хэлнэ.

8.6 Оролцогчид байр сууриа илэрхийлж дууссаны дараа асуудал оруулагч талаас шаардлагтай гэж үзвэл оролцогчдод болон урилгаар оролцож буй гэрч, шинжээч, төрийн албан хаагч, судлаач бусад зочдод хандан асуулт тавьж болно.

8.7 Асуулт хариулт дууссаны дараа хэлэлцүүлэгт оролцогч та болон асуудал оруулагчдын зүгээс санал дүгнэлт хэлнэ. Ингэхдээ нэг хүнд 1-2 минутын хугацаа олгоно.

8.8 Хэлэлцүүлэг даргалагч хэлэлцүүлэгийг хааж үг хэлнэ.

8.9 Хэлэлцүүлэгт оролцогч бүдүүлэг үг хэллэг хэрэглэх, бусдыг дооромжлох, яриаг нь таслах, өмнөөс нь үг хэлэх, хашгирах, шүгэлдэх, хөлөө дэвслэх зэрэг бусдын үгээ чөлөөтэй хэлэхэд нь саад учруулсан үйлдэл гаргавал хэлэлцүүлэг даргалагч дэг баримтлахыг шаардах бөгөөд шаардлагыг үл биелүүлвэл зохион байгуулагчид уг оролцогчийг танхимаас гаргаж болно.

Ес. Хэлэлцүүлэгийн үеийн гарсан саналыг шийдвэрт тусгах :

9.1 Нээлттэй хэлэлцүүлэгээр хэлэлцсэн төслийн талаарх саналыг бүх хэлбэрээр авч дууссаны дараа төсөл боловсруулагч ажлын хэсэг төслийн эхийг ажлын 3 хоногт багтаан эцэслэн боловсруулж , сумын ИТХ-ын дарга, сумын Засаг даргад өргөн мэдүүлж танилцуулна.

9.2 Иргэний танхимд төслийн талаар ирүүлсэн бүх санал тухайн санал төсөлд хэрхэн тусгагдсан, эс тусгагдсаныг тайлбарласан тайлбар бүхий хавсралттай төслийн шинэчилсэн хувилбарыг Танхимын мэдээллийн самбарт байрлуулах болон орон нутгийн мэдээллийн хэрэгслэл /сонин телевиз/-ээр мэдээлнэ.

9.3 Энэхүү журам нь хүн бүрийн саналыг нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллагаас гаргах шийдвэрт заавал тусгах үндэслэл болохгүй. Харин гаргахаас өмнө иргэд байр суурь, саналаа чөлөөтэй илэрхийлж, сонсгох илүү өргөн боломж бий болгож, иргэдийн оролцоог шийдвэр гаргах түвшинд хүргэх ач холбогдолтой болно.

Арав. Санхүүгийн эх үүсвэр , байр техник, хэрэгсэл:

10.1 Иргэний танхимын үйл ажиллагааны зардал нь орон нутгийн төсвөөс бүрдэнэ.

10.2 Танхимын зөвлөл нь жил бүрийн үйл ажиллагааны зардал, ажилтны цалин хөлсний тооцоо судалгааны төслийг хэлэлцэн, олонхийн саналаар батлагдсан төслийг сумын ИТХ-д өргөн мэдүүлнэ.

10.3 Танхимын байр, түүний үйлчилгээ, техник, тоног төхөөрөмжөөр хангах, өдөр тутмын ажлыг хариуцсан гэрээт ажилтны цалин хөлстэй холбоотой төсвийг сумын ИТХ-ын төсөвт тусган жил бүр санхүүжүүлнэ.

Арван нэг. Бусад зүйл :

11.1 Орон нутгийн хэмжээнд байгаль, цаг уурын байдал хүндэрч нийтийг хамарсан гамшиг тохиолдох, нийтийн эрүүл мэнд аюулгүй байдлыг хамгаалах онцгой нөхцөл байдал үүссэний улмаас Иргэний танхимд болох хэлэлцүүлгийг сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга хойшлуулах буюу цуцлаж болно. Хойшлогдсон хэлэлцүүлгийг зохион байгуулах тухай зарыг энэхүү журмын дөрөвдүгээр зүйлийн дагуу олон нийтэд мэдээлнэ.

11.2 Иргэний танхимын хэлэлцүүлэг нь Монгол хэл дээр явагдана.



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2014 оны 01 сарын 13 өдөр

Дугаар 06

Жаргалант

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Сумын 2013 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийг хангалттай гэж дүгнэсүгэй.

Хоёр. Сумын 2014 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг нэгдүгээр хавсралтаар, бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Гурав. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч, биелэлтийг хагас, бүтэн жилээр сумын ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулж ажиллахыг сумын Засаг дарга /Д.Сайнбилэг/-д газрын даамал Д.Пагмасүрэн нарт даалгасугай.



ДАРГА *Д.Сайнбилэг* Д.ГАНТӨМӨР

1513107

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны
06 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт



НЭГ. БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ДЭВСГЭР ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ

№	Сумын нэр	Багийн нэр	Байршил	Талбайн солбицол	Газрын хэмжээ /м2/	Зориулалт	Техникийн нөхцөл	Хариуцах эзэн
1	Жаргалант	Эмээл толгойн 4-р баг	"Сүмбэнцацал" ШТСтанцын чанх урд талд	X=536872.9843 Y=5207227.2730 X=537112.9843 Y=5207227.2730 X=537112.9843 Y=5207057.2730 X=536872.9843 Y=5207057.2730 X=536872.9843 Y=5207227.2730 X=537112.9843 Y=5207227.2730	40800	Хүүхэд залуучуудын спорт урлагийн талбай	ОНХСангаас	Д.Сайнбилэг Д.Пагмасүрэн
2	Жаргалант	Эмээл толгойн 4-р баг	Холбооны урд	X=536234.2198 Y=5207445.7734 X=536332.5811 Y=5207463.8025 X=536342.4347 Y=5207414.7831 X=536244.3430 Y=5207395.3401 X=536234.2198 Y=5207445.7734	5000	Цэцэрлэгт хүрээлэн	ОНХСангаас	Д.Сайнбилэг Д.Пагмасүрэн
3	Жаргалант	Эмээл толгойн 4-р баг	Хөх нуур дэлгүүрийн хойд талд	X=536487.5550 Y=5207578.017 X=536486.6339 Y=5207582.8135 X=536492.8755 Y=5207584.1353 X=536493.8221 Y=5207579.2268 X=536487.5528 Y=5207578.0166 X=536486.6339 Y=5207582.8135	30	Дэлгүүр	Дуудлага худалдаа	Д.Сайнбилэг Д.Пагмасүрэн
4	Жаргалант	Эмээл толгойн 4-р баг	Шинэ дэлгүүрийн баруун талд	X=536422.3325 Y=5207657.5996 X=536436.9636 Y=5207660.9060 X=536434.7810 Y=5207670.6650 X=536420.1617 Y=5207667.3070 X=536422.3325 Y=5207657.5996	150	Худалдаа үйлчилгээ	Дуудлага худалдаа	Д.Сайнбилэг Д.Пагмасүрэн

ХОЁР. ХАА-Н БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ДЭВСГЭР ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ

№	Багийн нэр	Байршил	Талбайн солбицол	Газрын хэмжээ	Зориулалт	Техникийн нөхцөл	Хэрэгжүүлэх хугацаа				Хөрөнгө оруулалтын хэмжээ	Хариуцах эзэн
							I	II	III	IV		
1	Эмээл толгойн 4-р баг	Малтай лагерийн зам дагуу		1 га	Чацаргана тариалах	Төсөл сонгон шалгаруулалт		x	x			Д.Сайнбилэг Д.Пагмасүрэн
2	Эмээл толгойн 4-р баг	Байдрагийн голын арал		1 га	Чацаргана тариалах	Төсөл сонгон шалгаруулалт		x	x			Д.Сайнбилэг Д.Пагмасүрэн

	гудамж	X=536542.6902 Y=5207918.4175 X=536565.2180 Y=5207915.7880 X=536566.8280 Y=5207933.5050 X=536544.6052 Y=5207935.2914																	
		X=536901.2572 Y=5207887.8917 X=536955.5350 Y=5207878.7190 X=536951.9688 Y=5207854.1851 X=536896.8210 Y=5207861.7710 X=536901.2572 Y=5207887.8917	2	1100	Гэр бүлийн хэрэгцээ					x	x	x	x						Д.Сайнбилэг Д.Пагмасүрэн
	Эрдэнэ толгойн 1,2-р гудамжны эхэнд	X=537339.5232 Y=5207410.2980 X=537369.5232 Y=5207410.2980 X=537369.5232 Y=5207370.2980 X=537339.5232 Y=5207370.2980 X=537339.5232 Y=5207410.2980	2	1200	Гэр бүлийн хэрэгцээ					x	x	x	x						Д.Сайнбилэг Д.Пагмасүрэн
		6 иргэнд 0,33 га газрыг	6	3340м2															

ТАВ. ЖАРГАЛАНТ СУМЫН ӨВӨЛЖӨӨ,ХАВАРЖААНЫ ДООРХИ ГАЗРЫГ ЭЗЭМШҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨЛТ

Бэлчээр ашиглалтын хэсгийн дугаар	Хэсэг бүлгийн оноосон нэр	Эзэмшүүлэхээр төлөвлөсөн өвөлжөө,хаваржааны доорхи газар				Хэрэгжүүлэх хугацаа				Хариуцах эзэн	
		Газрын оноосон нэр	Байршлын солбицол		Газрын хэмжээ	Усан хангамжийн байдал	I	II	III		IV
			Өвөлжөө	Хаваржаа							
6-р	Баянхөндий	Дөт Далай хайрхан	өвөлжөө		0,07		x	x			Д.Сайнбилэг Д.Пагмасүрэн
6-р		Зүүн хүүш		хаваржаа	0,07		x	x			Д.Сайнбилэг Д.Пагмасүрэн
8-р	Цохиот	Мандалын Агуйт	өвөлжөө		0,07		x	x			
8-р				хаваржаа	0,07		x	x			Д.Сайнбилэг Д.Пагмасүрэн
6-р	Баянхөндий	Дөтийн Булшит	өвөлжөө		0,07		x	x			Д.Сайнбилэг Д.Пагмасүрэн
6-р	Баянхөндий	Бөөрөгийн хонд		хаваржаа	0,07		x	x			Д.Сайнбилэг Д.Пагмасүрэн
5-р	Цагаан дөрөлж	Ховлийн ам	өвөлжөө		0,07		x	x			Д.Сайнбилэг Д.Пагмасүрэн

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны
06 дугаар тогтоолын 02 дугаар хавсралт

ЖАРГАЛАНТ СУМАНД ХЭРЭГЖҮҮЛЭХ 2014 ОНЫ БЭЛЧЭЭРИЙН
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэх хугацаа	Хариуцах эзэн	Зардлыг хаанаас санхүүжүүлэх
Нэг. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар	1.1. Хөдөөгийн 3 багт мал угаалгын ванн барих	5-6-р сард	Сумын засаг дарга, багийн засаг дарга, МЭҮТасаг	ОНХСангаас
	1.2. Өвс тэжээлийн нөөц агуулахын барилга засах	5-7-р сард	Сумын засаг дарга, багийн засаг дарга, МЭҮТасаг	ОНХСангаас
Хоёр. Засаг даргын тамгын газрын хэрэгжүүлэх ажил	1.3. Малчдын бүлгүүдийн нэгдсэн мэдээллийн сантай болох	3-7 сарын хооронд	Сумын засаг дарга, багийн засаг дарга, газрын даамал	Өөрсдийн санаачилгаар
	1.4. өвөлжөө хаваржааны газрыг хортон мэрэгчдээс хамгаалах хялбар арга ажиллагааг төлөвлөх	Эхний хагас жилд	Сумын засаг дарга, багийн засаг дарга, газрын даамал, байгаль хамгаалагч, ХААН түшмэл, малчид	Өөрсдийн хүчээр
	1.5. Ган, зуд байгалийн гэнэтийн аюул гарсан үед яаралтай арга хэмжээ авах	Тухайн үед нь	Сумын засаг дарга, багийн засаг дарга, газрын даамал, байгаль хамгаалагч, малчид	Баталсан төсвийн хэмжээгээр
	1.6. Өвөлжөө, хаваржааны бэлчээрийг зун, намрын улиралд чөлөөлөх, хамгаалах ажлыг зохион байгуулах	6-9-р сарууда Д	Сумын засаг дарга, багийн засаг дарга, газрын даамал, байгаль хамгаалагч, малчид	Өөрсдийн хүчээр
	1.7. Малчид өөрсдийн хүчээр хашаа хороогоо засварлах, шинээр барих, гар тэжээл бэлтгэх, өвөлжөө, хаваржаа зуслан намаржааныхаа газарт тусгай хогийн цэг, жорлонтой болох	Жилдээ	МАлчид, малчдын бүлгийн ахлагч	Өөрсдийн санаачлагаар

	Улсын тусгай хамгаалалттай газар нутагт өвөлжөө, хаваржаа эзэмшиж байгаа иргэдийн эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох	Жилдээ	Сумын Засаг дарга, Багийн дарга, ТХГНутгийн байгаль хамгаалагч	
	Өвөлжөө бууцаа түрээсэлж гадны малчид оруулж байгаа малчдын өвөлжөө, хаваржаа эзэмших эрхтэй нь хариуцлага тооцох	Жилдээ	Сумын Засаг дарга, Газрын даамал, багийн дарга	Тухайн үед
	1.9. өвөлжөө, хаваржааны координатыг тогтоох	Жилдээ	Сумын Засаг дарга, Газрын даамал, багийн дарга	Өөрсдийн хүчээр
Гурав. Багийн ИНХ, багийн засаг даргын хэрэгжүүлэх ажлууд	1.10. Малчдын гаргасан хүсэлтийн үндсэн дээр өвөлжөө, хаваржааны доорхи газрыг эзэмшүүлэх	Жилдээ	Багийн ИНХурал, Багийн засаг дарга	Өөрсдийн хүчээр
	1.10. Баг, малчдын бүлгийн хурлаар дундын отрын нөөц нутаг бий болгох асуудлыг хэлэлцэж багийн ИНХ-ын шийдвэр гаргуулах	Тухайн үед нь	Багийн ИНХурал, Багийн засаг дарга, малчид	Өөрсдийн санаачлагаар
	1.11. сумын Бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг багийн иргэд, аж ахуйн нэгж байгууллагад хүргэж сурталчилах	Тухайн үед нь	Багийн ИНХурал, Багийн засаг дарга, малчид	Өөрсдийн санаачлагаар
	1.12. өвөлжилтийн бэлтгэл ажлыг бүх малчид, малчидын бүлгээс нэгтгэн авч судалгаа тайланг тамгын газарт ирүүлэх	9,10-р сард	МЭҮТасгийн дарга, Багийн ИНХурал, Багийн засаг дарга, малчид	Өөрсдийн санаачилгаар
	1.13. ашиглалтгүй бэлчээрийг ашиглах, 1,2,3-р багт худаг засах	7-9-р сард	МЭҮТасгийн дарга, Багийн ИНХурал, Багийн засаг дарга, малчид	ОНХСангаас



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2014 оны 01 сарын 29 өдөр

Дугаар 07

Жаргалант

Г Нөхөн сонгуулийн тов зарлах тухай Г

Аймаг, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.4.1 дэхь заалтыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Орон нутгийн нөхөн сонгуулийг 2014 оны 02 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн товлон зарласугай.

Хоёр. Орон нутгийн нөхөн сонгуулийн санал хураалтыг 2014 оны 02 дугаар сарын 26-ны өдөр явуулахаар тогтоосугай.

Гурав. Нөхөн сонгууль зохион байгуулахад гарах зардлыг санхүүжүүлж ажиллахыг сумын Засаг дарга Д.Сайнбилэгт даалгасугай.

ДАРГА  Д.ГАНТӨМӨР



1513111



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2014 оны 01 сарын 29 өдөр

Дугаар 08

Жаргалант

Орон нутгийн сонгуулийн хэсэг, нутаг
дэвсгэр төвийг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, Аймаг, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.4.1 дэхь заалтыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Сонгогчдын санал авч тоолох зорилгоор сонгуулийн хэсэг, нутаг дэвсгэрийн төвийг дор дурьдсанаар байгуулсугай.

№	Хэсгийн дугаар	Нутаг дэвсгэр	Сонгогчдын тоо	Хэсгийн төв
1	290-р хэсэг	Нам толгойн 1-р баг		Соёлын төв
Нийт				

ДАРГА  Д.ГАНТӨМӨР



1513109



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 01 сарын 29 өдөр

Дугаар 09

Жаргалант

Сумын сонгуулийн хороо
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, Аймаг, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.4.1 дэхь заалтыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Сумын сонгуулийн хороог дор дурьдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Дарга	Ж.Туяа
Нарийн бичгийн дарга	Д.Уранчимэг
Гишүүдэд	Д.Тайванжаргал
	Ц.Сарантуяа
	Ө.Бямбаа
	С.Жаргалсайхан
	Н.Эрдэнэ-Очир

Хоёр. Сонгуулийн хууль тогтоомж, холбогдох заавар, журмыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж ажиллахыг сонгуулийн хорооны бүрэлдэхүүнд даалгасугай.

ДАРГА  Д.ГАНТӨМӨР



1513113

togtool-2014